

БИБЛИ СУДАР МОНГОЛ ХЭЛНЭЭ ОРЧУУЛАГДСАН ТҮҮХЭЭС¹

С.Янжисүрэн (Ph.D)

Р.Ганболд (Докторант)

МУИС. НШУС.

Шашин Судлалын Тэнхим

Түлхүүр үгс: Христийн сургаал, Библи судар, монгол орчуулга, Жонни, Иаков Шмидт, Номт, Бадмаа, Сталлибрасс, Сван, Эдкинс, Шересчевский, Ларсон, Алмблад, Матай, Гэндэн, Рэнчиндорж, Стюарт Гунзел, Китамура, Жон ба Алтаа Гиббенс, Монголын Библийн Орчуулгын Хороо, Монголын Библийн Нэгдсэн Нийгэмлэг.

Товч утга: Христосийн шашны ертөнцийг үзэх үзлийн нэвтэрхий толь, Библи судар монгол хэлнээ орчуулагдсан түүх, орчуулгуудын зарим онцлогийн талаар эл өгүүллэгт өгүүлэх болно. Библи судрын анхны монгол орчуулгуудын эх хувиуд одоо олдохоо байсныг библийг сонирхон судлагчид болон судалгааны байгууллагууд дахин хэвлэж байгаа нь Христосын шашны ертөнцийг үзэх үзэл, философи сэтгэлгээний онцлог, шашны агуулга, зан үйлтэй танилцах өргөн боломжийг нээж байна. Зарим талаар монголчуудад Бурханы шашны ертөнцийг үзэх үзэлтэй Христосын шашны ертөнцийг үзэх үзлийг харьцуулан үзэх, түүнд авах гээхийн ухаанаар хандах боломжийг олгож байна.

Монголчууд шашны ном зохиолуудыг эртнээс монгол хэлнээ хөрвүүлэн уншиж судалж ирсэн баялаг түүхтэй юм.

Санскрит хэлт Энэтхэгийн утга зохиолтой эрт үеэс холбогдсон монголчууд уламжлалт Бурханы шашны ном зохиолыг XIII-XIV зуунд төвд хэлнээс орчуулж эхэлсэн үеэс буддизмийн мэдлэг ухаанаас хөндийрөлгүй өнөөдрийг хүрч ирсэн.

Италийн санваартан John² Monte Corvino Юань гүрний үед хааны ордонд ойр байж “Шинэ Гэрээг” монгол хэл үрүү орчуулж байсан гэх мэдээ байдаг ч тэр үеийн дурсгал одоогоор олдоогүй байгаа юм.

Хүн төрөлхтөний утга соёлын томоохон өв, дэлхийн хэд хэдэн шашны ертөнцийг үзэх үзлийн эх булаг болсон Библи судрыг XIX зуунд монгол хэлнээ бүрэн орчуулсан боловч монголд Бурханы шашны ном зохиол өргөн тархсан шиг олон нийтийн хүртээл болж чадалгүй XX зууны сүүлч үетэй золгосон түүхтэй. Энэ нь Бурханы шашин соёл монголчуудын соёлын хөрсөнд нь тал бүрээр үндэслэн ургасантай шууд холбоотой.

Библи судар дэлхийн олон үндэстний хэл дээр орчуулагдсан бөгөөд монгол хэлэнд монгол бичгээр 1800 гаад оны эхнээс түүний доторх номуудыг салгаж дан дангаар нь, мөн Хуучин Гэрээ, Шинэ Гэрээ аль аль нь, бас хамт цогцоороо Ариун ном, Ариун Библи зэрэг нэртэйгээр орчуулагдсаар ирсэн нь дараах байдалтай байгаа юм.

Олон орнууд тухайлбал англи хэлт улсууд өөр өөрийн хэл дээр шүтдэг шашныхаа ном судрыг унших шаардлагаар Библийг орчуусан түүхтэй ч орчуулагдах хүртлээ нэлээдгүй

1. Өгүүллэг “Монголын ард түмнүүдийн нийгэм-соёл, улс төрийн бодит байдал: уламжлал ба орчин үе” сэдэвт хамтын ажиллагааны судалгааны хүрээнд бичигдэв. Эта статья написана под проектом «Буддизм в социокультурных и политических реалиях монгольских народов: традиции и современность»


2. У.Эрдэнэбат. Дундад зууны монгол оронд загалмайтны шашны урсгал нэвтэрч байсан товч түүхээс. УБ., 2009, Monograph series, Volume 2, Антоон Мостэрт Монгол Судлалын Төв.

бэрхшээлийг туулсан байдаг. Англи хэл дээр Библийг орчуулж цаасан дээр буулгах ажлыг 1380-аад оны үед эхлүүлсэн Оксфордгийн их сургуулийн профессор Жон Виклифийг John Wycliffe) сүм хийдүүд бүхэлдээ эсэргүүцэж байжээ. Гэсэн хэдий ч түүний орчуулга 1382 онд бүрэн дууссан бөгөөд англи хэл дээрх анхны Библи судар болсон юм. Теологич Виклиф бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн Библийн номлолуудыг Латин хэлнээс орчуулж байсан ба түүнийг дэмждэг Lollards болон John Wycliffe-ийн туслах Purvey нарын хүчин зүтгэлтээр анхны библийн англи хэлт эх бий болсон байна. Тухайн үедээ Жон Виклифийг европод Библийн эсрэг үзэлтэн гэж үздэг байв. Библийг орчуулсанд нь Виклифт дургүйцсэн Пап лам зарлиг гаргаж түүнийг нас барснаас 44 жилийн дараа шарилыг нь ухаж гаргаад жижиглэн голд үйж байжээ³.

Үүнээс үзвэл Библийн судрыг орчуулах нь хориотой байсан төдийгүй эрт үедээ нэлээд эрсдэлтэй ажил байж, англи хэлнээ орчуулах ажлыг эхлүүлэгч нь миссионер, судлаач, эрдэмтэн байсан онцлогтой. Ийнхүү нэгэнт Библи судар англи болон бусад хэлүүд дээр орчуулагдсаар түүнийг орчуулах, хэвлэх нь шашин номоо дэлгэрүүлж байгаа хэлбэр болсон учир анхны гадаад хэлт Библиүүдийг бодвол монгол хэл дээр Библийг үйлдэхэд дээрх адил бэрхшээл тулгараагүй ч монголчууд төдийлөн дэмжээгүй байна. Учир нь монголчуудын дунд язгуурын шүтлэг бөө мөргөл, уламжлалт шашин шүтлэг буддизм их хүчтэй байсан юм. Үүнээс болсон уу, эртхэн үеийн орчуулгын хувиуд манайд хадгалагдаж үлдээгүй шахуу юм. Гэхдээ тухайн үед монголчууд бүгдээрээ Христосын шашныг дэмжээгүй гэж хэлэх нь учир дутагдалтай.

1800 гаад оны эхэн үед Халимаг хэл дээр Библийг орчуулан гаргасан явдал нь Монгол хэл дээр Библийн судар орчуулагдах үндэс болжээ. Оросын зарим язгууртнууд тухайлбал ханхүү Голицин Протестант шашинд орсон нь нэгдүгээр Александр хаанд нөлөөлж, улмаар тэд Протестант шашинд тал өгч ном судрыг нь түгээхэд ихээхэн дэмжлэг үзүүлжээ. Энэ үед Орос оронд зөвхөн Протестант бус бас Католик шашны сүм хийдийн номлол зэрэгцэн хөгжиж судар ном нь хэвлэгдэж байв. Үүний сацуу Орос улсад Библийн нийгэмлэгүүд хэд хэдэн газар байгуулагджээ.

Волга мөрний эргээр суурьшсан халимагуудын дунд 2 жил ажиллаж хэлийг нь сурсан Орос, герман гаралтай Исаак Шмидт (Isaac Shmidt) 1815 оноос Хуучин гэрээг халимаг хэлэнд тод үсгээр буулгаж эхэлжээ. Түүний орчуулга, хэвлэлийн талаар эрдэмтэн Charles Bawden, Манлажав нар . . . эл орчуулга 2 удаа хэвлэгдсэн бөгөөд эхний хэвлэл нь европ номтой адил байсан, 2 дахь хэвлэл нь бурханы шашны судартай төстэй, хуудас бүгд нь салангид⁴ гэснээс үзвэл 2 дахь удаагийн хэвлэлтийг бурханы шашны судар номтой төстэй хэвлэсэн нь буддын соёлын "хэлбэрээр" Хуучин гэрээний "агуулгыг" түгээх нь зохимжтой гэж орчуулагч сэтгэсэн байж болох юм. Эл хэвлэл манай улсад хадгалагдаж үлдсэнгүй ч гадаадын номын сангуудад, тухайлбал Берлиний номын санд хадгалагдаж байгаа юм байна.




3. <http://www.greatsite.com/timeline-english-bible-history/>

4. Оюуны хэлхээ II, Christianity and Mongolia, Ulaanbaatar., 2006, pp.155-156

Эндээс үзвэл монголчууд хэд хэдэн шашины ертөнцийг үзэх үзлийг нэгэн зэрэг үзэж судлах боломжийг XIX зуунд олж авсан ч харьцуулсан судалгаа явагдсангүй судар номууд нь тус тусдаа монгол хэлнээ хөрвүүлэгдсээр ирсэн байна. Оросын судлаач Ольга Волкавагийн судалгаагаар бол Кавказ дахь Шотландын миссионеруудын газрын гишүүн байсан Пинкертоны \Pinkerton\ өөрийн нутагт нэгтнээ Библийг Халимаг хэл үрүү орчуулсныг мэдээд 1812 онд Англи ба гадаад Библийн нийгэмлэгт \British & Foreign Bible Society\ “Буриад Христосын шашинд орох бэлтгэл хангагдсан”⁵ гэсэн мэдээ бичжээ.

Тэрээр судалгаандаа нутаг нэгтэн гэж хэн болохыг бичсэнгүй. Бас Библи гэснээс Хуучин, Шинэ гэрээ алин болохыг ч заасангүй, бодвол Пинкертоны нутаг нэгтэн нь Исаак Шмидт юм болов уу.

Гэхдээ энд бичсэн орчуулгуудын он цаг нь зөрж байна, Манлажав судлаачийн бичсэнээр библийг 1815 оноос орчуулж эхэлсэн байдаг. Мөн “Эхлэл” номыг 1833 онд, “Гарсан нь” номыг 1837 онд, “Левит” номыг 1839 онд тус тус орчуулан гаргажээ. Аль нэгэн соёлыг аль нэг ард түмэн хүлээн авах эсэх нь түний утга зохиол хэр яруу тунгалаг тухайн ард түмний хэл дээр бууснаас хамаарах нь тодорхой. Энэ ч утгаараа Библийн орчуулга чамбай, нягт ажиллагаа шаардаж байсан хийгээд нөгөө талаас орчуулагч монгол хэл, монгол хэлний бичгийн хэлийг сайтар судлаж эзэмшихэд нэлээдгүй цаг хугацаа зарах нь тодорхой юм. Орчуулгын байдлаас харахад тэрээр сонгодог монгол бичгийн хэл найруулгыг сайтар эзэмшсэн нь харагддаг юм.



1833-40 оныхооронд Пэнтатухын⁶ таван номыг тус тусад нь хэвлэн гаргахдаа “Бурхан”, “Иахова” гэдэг үгийг том фонтоор онцлон тэмдэглэсэн байдаг нь монгол бичгийн мөртэтгэх ёстой төстэй байдаг юм. Харин 1840 онд Хуучин гэрээг бүхэлд нь хэвлэн гаргахдаа ийм тодотгол хийгээгүй байна.

Шинэ Гэрээг монгол хэлэнд орчуулсан түүх нь дараахь байдалтай байна, үүнд: 1812 оны

12 сард Санкт Петербург хотноо Оросын Библийн нийгэмлэг байгуулагдаж 1818 онд Иркутск хотноо салбараа байгуулсан нь Библийг буриад хэлэнд орчуулахад гол түлхэц болжээ. Оросын хааны удирдамжаар 1818 онд Утайн Номт \Унгаев\, Бадма Морогун \Моршунаев\ нэртэй хорь буриад эрс Санкт Петербург хотноо ирж 10 гаруй жил үргэлжилсэн уйгагүй хөдөлмөрийн үр

5. Olga Volkova. The First Western Missionaries in Buriatia. Swedish Missiological Themes. Svensk Missions Tidskrift. Vol.93, No.1, pp.7-27

6. Хуучин гэрээ нь Тора-Хууль \Torah\ эсвэл Пэнтатух-Таван ном \Pentateuch\, Невим-Эш үзүүлэгч \Nevi'im\, Кетувим-Бичвэрүүд \Ketuvim\ гэсэн 3 үндсэн хэсгээс бүтэх ба хэсэг тус бүр тусгаар тусгаар номуудаас бүрдэнэ. Бүгд 39 ном жүүд, жүүдийн ертөнцийг үзэх үзлийн төлөвлөлийн түүхийг өгүүлдэг.

дунд Шинэ Гэрээг 1827 онд Яков Шмидтийн Jacob Shmidt⁷ удирдлага дор монгол хэлнээ орчуулж дуусгажээ.

Эндээс үзвэл Шинэ Гэрээг монголчуудаас анх буриадууд монгол хэлнээ оросуудын удирдамжаар орчуулсан бөгөөд үүнийг Оросын засгаас шаргуу дэмжиж, Англиас ерөнхийлөн захирач байсан нь тодорхой байна. Ийнхүү Хуучин хийгээд Шинэ Гэрээ хоёулаа буюу Библи судар сонгодог монгол хэлний бичигт буусан байна.

“1814 оноос Оросын Библийн нийгэмлэг Лондонгийн Номлогчдын Нийгэмлэгтэй \ London Missionary society\ хамтран ажиллах болж тэдний зорилго нь Буриадаар дамжин Монгол хийгээд Хятадад Христосын шашны сургаал, ном зохиолыг хүргэх явдал байсан ... бөгөөд 1818 оноос Манж хэл үрүү Библийг орчуулж эхэлсэн юм. Манж бичиг нь монгол бичигтэй нэлээд төстэй”⁸ гэж судлаач Ольга Волькова бичжээ.

Оросын харьяат Буриадын ард түмэнд оросын ард түмний шашин шүтлэг, соёл нөлөөлж тэд монгол хэлэнд оросуудын шүтдэг шашны ном судрыг орчуулсанд гайхах зүйлгүй юм. Тэгээд ч төрөөс нь бодлого болгон хэрэгжүүлсэн гэмээр юм. Харин эл үзэгдэл монголчуудын дунд тус шашны ном судар түгэх гол шалтгаан нь болжээ. Гэхдээ энд хөндлөнгийн удирдлага байсан байна.

1814 оны сүүлээр Лондонгийн Номлогчдын Нийгэмлэг шаардлагад нийцсэн, хариуцлагатай этгээдийг сонгож Сибирь дэх төлөөлөгчийн газраа хариуцуулахаар шийджээ. 1815 оны намар Роберт Ель \Robert Yuille\ гэх 1780-аад оны үед эцэг эх нь Ирландад дүрвэн гарсан шотланд эр Шинэ Гэрээг монгол хэлнээ орчуулахаар шийджээ. Түүний бүтээлийг хэвлэх бүх зардлыг Лондонгоос өгсөн боловч 10 жил хүлээсний эцэст түүний байгуулсан Христын номлогчдын сургуулийг дэмжихэд хүрсэн байна. Нэг үгээр хэлбэл тэр Библийг монгол хэлнээ хөрвүүлж чадсангүй.

Роберт Елийн хамтрагч нь Вилиам Сван \William Swan\ хэмээх өндөр боловсролтой Шотланд хүн байв. Ольга Волковагийн бичсэнээр тэрээр Шотландын банкинд кассчин, нягтлан бодогч хийж байсан бөгөөд Теологийн академид сурч байсан, сурч мэдэх эрмэлзэлтэй, өмнөө тавьсан зорилготой ер нь Лондонгийн шаардлагад нийцсэн хүн байсан тул 1818 оны 7 сард Петербургт ирсэн байна.

Сибирь үрүү илгээхээр сонгогдсон анхны номлогч нь Эдвард Сталибрасс \Eduard Stallybrass\ гэж Шотланд хүн байв. Түүний эцэг нь Христосын шашны лам хүн бөгөөд Сталибрасс Христосын шашны зүтгэлтэн болохоор шийджээ. Homertown College-д 20 настайдаа буюу 1814 онд элсэж жилийн дараа Лондонгийн Номлогчдын Нийгэмлэгт өргөдөл гаргажээ. Төлөв даруу, тэвчээртэй, хичээнгүй Сталибрассийн анкет, багш нарынх нь тодорхойлолт түүнийг итгэл даах хүн бөгөөд Христосын шашны гүнзгий мэдлэгтэй гэдгийг нотлон харуулдаг гэнэ. Сталибрасс нутгаа орхин Сибирь үрүү явахынхаа өмнө Христийн шашны номлогчийн охинтой гэрлэжээ.

Сталибрасстай гар нийлэн ажиллаж чадах хүнийг Корнелиус Рамн \Cornelius Rahmn\ гэж үзжээ. Тэрээр 1785 онд Шведэд төрсөн бөгөөд эцэг нь цэргийн албан хаагч дэслэгч хүн

7. Зарим судалгаанд Исаак Шмидт \Isaac Shmidt\ нэрээр бичсэн байдаг.

8. Olga Volkova. The First Western Missionaries in Buratia. Swedish Missiological Themes. Svensk Missions Tidskrift. Vol.93, No.1, pp.7-27

байв. Корнелиус Рамн 14 настайдаа Lund-ийн их сургуулийн хууль зүйн салбарт сурч байсан ба өөрөө хууль зүйн чиглэлд төдийлөн сонирхолтой биш байжээ. Тэрээр Латин, Грек, иврит хэл судалж байсан, Франц, Герман, Англи хэлтэй ба цэргийн албан хаагчдийн хүүхдийг сургадаг Принц Оскарын сургуулийн захирлын албыг хашиж байжээ. Санкт Петербургт эхнэр, охины хамт номлогч болохоор ирсэн байна.

Оросын Библийн нийгэмлэг (Russian Bible Society) номлогчдыг Орос уруу оруулахын өмнө тэдний аюулгүй байдалд анхаарал тавихыг Александр хаанаас хүссэнд хаан Сибирт байх хутагаанд нь аюулгүй байдлаар хангахыг зөвшөөрчээ. 1818 оны 12 сарын 5нд I Александр хаантай Петербургт уулзсаны дараа номлогчид чаргаар аян замдаа гарсан байна. Тэд гэр бүлээрээ чаргаар явсан бөгөөд Рамний эхнэр замдаа төрж хүү нь эндэж 1819 оны 3 сард Иркутскт иржээ. Иркутск хотын захирагч Трешкин номлогчдын аюулгүй байдлыг хангах үүргийг дээрээс хүлээсэн байна.

Сталибасс, Рамн нар монгол хэл сурч эхэлсэн ч гарын авлага, ном сурах, толь бичиг туйлын хомс байжээ. Тэд Иркутск хот нь Оросын хот учир Буриадуудад Христосын шашны номлолыг түгээхэд тийм ч зөв газар биш гэж үзсэн байна. Тиймээс номлол явуулах газраа шинэчлэхээр шийдэж Хиагтад хүрчээ. Хилийн ойролцоо байх нь Хятадад хүрэх нэг гарц гэж Сталибасс тооцож байсан гэж үздэг.

Бас Буриадуудын олонх нь бичиг үсэггүй байсан нь туйлын хүндрэлтэй асуудал болсон бололтой.

Хиагт хот байрладаг Сэлэнгийнск аймаг нь Сэлэнгэ мөрний баруун эрэг дагуу оршдог, гэхдээ маш цомхон нутаг байлаа. Ердөө 200 гаруй байшинтай 1000 гаруй оршин суугчтай бас 1000 орчим цэрэгтэй⁹. Сталибасс эл нутгийг газар зүйн байршлийн хувьд монголчууд хамгийн их цугларах газар гэж үзэж номлол явуулах төв цэгээр сонгожээ. Ингэхдээ Хорь буриадууд хийгээд Халх Монголчуудын аль аль нь энэ нутагтай холбогдоно гэж үзсэн байна. Гэвч тэр үед Сэлэнгийнскт байсан сүм нь Ортодокс сүм байсан учир номлогчдыг протестантчууд гэж мэдээд хамтран ажиллах, туслахаас татгалзсан байна. Гэсэн хэдий ч 1820 оноос эхлэн Сталибасс Сэлэнгийнскэд амьдрах болжээ.

Байр түрээслэх нь барихаас үнэтэй учир Лондонгийн Номлогчдын нийгмэлэгт уламжилж улмаар Александр хаанаас Сэлэнгэ мөрний сав газарт 3 хэсэг газар авч 1821 онд гэр оронтой болцгоосон байна. Роберт Елийн эхнэр 1827 онд хижиг өвчнөөр нас барсан гэсэн судалгаа¹⁰ байдаг боловч нутгийн олон тэдний амьдралаа босгосон газрыг Англичанка (англи эмэгтэй) гэж нэрлэдэг, ингэж нэрлэсний учир нь номлогчдын эхнэр хүүхэд нийлсэн 5 эмэгтэйн нэг нь голд үсэрч амиа хорлосноос ингэж нэрлэсэн гэдэг ажээ.

Тэд Библийг монгол хэл дээр орчуулахын зэрэгцээ орон нутгийнхны шашин шүтлэгт ажиглалт, судалгаа хийж байв.

18 настай Ринчен гэх нэртэй орос, монгол хэл мэддэг, уншиж бичиж чаддаг хүүг Роберт Ель бичээчээр ажиллуулдаг байжээ. Хариуд нь тэр хүүд унших ном өгдөг байж, харин өгдөг

9. Мөн тэнд, pp.14


10. С.В.Чимиддорж "The trip of Kori Buryats to the White Tsar. Middle Ages and New Age: Essays on the Khor Buryats history", Ulan-Ude, 2001

ном нь библийн номууд байсан гэдэг. Сталибрассийн гэртний ч багавтар сургууль нээж хожим түүнийгээ өргөтгөжээ. Магадгүй ийм замаар буриадуудыг шашин номондоо татдаг байсан болов уу.

Буриадууд бөө мөргөл, бурханы шашин зэрэг өөрсдийн язгуурын болон уламжлалт шашин шүтлэгтэй тул тийм ч амархан өөр шашинд ороогүй нь тодорхой ч номлогчдын зан харьцаа, аядуу зовлон, нөхөрсөг байдал нь нутгийн олонд нөлөөлж тэдэнд монгол хэлнээ библийг орчуулж дуусгах боломжийг олгосон байх. Бас тэдний хөдөлмөрч, өмнөө тавьсан зорилгодоо хүрэх чармайлт нь нөлөөлсөн нь дамжиггүй. Бас тэрчлэн ертөнцийг үзэх үзлийнхээ хувьд Оросын шашин шүтлэг нь Протестант урсгалтай нэг язгууртайнхаа хувьд оросын засаг захиргаанд багтдаг буриадуудад тэс өөр, харийн зүйл байгаагүй байх.

1829 онд Сталибрас, Ель нар орчуулсан “Эхлэл” номоо хэвлэжээ. Гэхдээ тэд хоорондоо нэлээд зөрчилтэй байсан бололтой бөгөөд Ель хэвлэлд арбитрын үүрэгтэй оролцож Сталибрассийн орчуулгыг эцсийн шатанд нь байнга өөрчилж байсан нь орчуулагчийн дургүйг нэлээд хүргэжээ.

Ольга Волковагийн эшэлснээр харин Сталибрас, Сван нар гар нийлж ажилладаг байсан ба Шинэ Гэрээний монгол орчуулгын эцсийн хувилбар дээр ч тэд хамтарсан байна. Тийм ч учраас Сталибрас, Сван нарын нэрээр хэвлэгдсэн хэрэг. Хэрэг дээрээ энэ орчуулгад буриад эрс Номт, Бадма, бичээч хүү Ринчен, “хянагч” Ель бас хамтран зүтгэгч Рамн нарын хувь хандив үлэмж байсан нь тодорхой.





“Бидний эзэн ба тонилгогч Иесус Христосийн Шинэ Тестмент хэмээгч ном нь оршвой. Вилиам Сван, Эдуард Сталибрас хоёр нь үүнийг грек эхээс монгол хэлэнд орчуулав.

Англи орны Лондон хот, 1846 оноо тараагдав”



хэмээсэн оршлын эл үгнээс Шинэ Гэрээг Сталибрас, Сван нар грек хэлнээс орчуулсан нь тодорхой байгаа ба харин англи хэл дээрх дотор хавтасны үгнээс Сталибрас, Сван нар нэлээд олон жил сибирьт амьдарсны бүтээл болсон үүнийг “Англи хийгээд гадаад библийн нийгэмлэг” хэмээх байгуулга санхүүжүүлэн хэвлэсэн гэдэг нь харагдаж байна. Ийнхүү Христосын шашны эх сурвалжийг буриад монголчуудын оролцоотойгоор гадаадын хүн монгол хэлнээ хөрвүүлэн, гадаадын байгуулга санхүүжүүлж, гадаадад хэвлэсэн байна.

1880 онд Санкт Петербург хотноо тус орчуулга хэвлэгдэж жилийн дараа буюу 1881 онд манж бичгээр хэвлэжээ.


1894 онд Жозеф Эдкинс (Joseph Edkins), Самуэл Черешевский (Samuel Schereschewsky) нар “Матайн сайн мэдээ” номыг редакторлон хэвлүүлсэн байна.




Удалгүй 1880 онд “Шинэ гэрээг” хянан тохиолдуулан Лондонд хэвлэжээ.



1900 онд “Матайн сайн мэдээ” номыг тусад нь хэвлэв (зүүн талд). 1913 онд Эхлэл, Сайн мэдээний номуудыг сайжруулан хэвлэв (баруун талд). Уг ажлыг Ларсон, Алмблад нар хийжээ.




1900-гаад оны эхэн үед Библийн номуудыг дахин хэвлэх болжээ. Тухайлбал, 1921 онд хэвлэсэн “Сургаалт үгс” номыг зурагт үзүүлсэнчлэн “Соломоны эрдэнэ үгс” нэрээр монгол бичгээр хэвлэж, 1939 онд “Дуулал” буюу “Псалм”-ийг дээрхийн адил монгол бичгээр хэвлэсэн байна.



1899 онд Англи хийгээд гадаад Библийн нийгэмлэг \British and Foreign Bible Society\ Edward Stallybrass, William Swan нарын орчуулгад дулдуйдсан David Stenberg, Нэцээгэрд нарын бүрэн бус монгол орчуулгын хувилбарыг хэвлэжээ. Нэцээгэрд гэж монгол хүн байсан гэдэг. Энэ орчуулга Библийн “Матайн сайн мэдээ хүртлэх” 4 номын орчуулга байгаад 1899-1901 оны хооронд үргэлжилсэн Манжийн төр, гадаадын худалдаачид болон христосын номлогчдын эсрэг Хятадын дайнд \Boxer rebellion\ орчуулагч David Stenberg амь үрэгдэж түүний удирдан хийсэн орчуулга ч устгагдсан байна. Орчуулгыг бараг бүгдий нь устгасан гэж үздэг. Өнөө хэр тухайн орчуулгын хувилбар огт олдоогүй юм.

Боксёрын хувьсгалын үед хятадын хойд талаар орж ирсэн Христосын шашны номлогчдыг сүм хийдүүдийнх нь хамт устгасан бөгөөд энд олон тооны номлогч лам, шашны зүтгэлтнүүд амиа алдаж, ном зохиолуудыг нь галдан шатаажээ.

1935 онд Хуучин гэрээг “Хуучин тогтоолын ариун шаштирын товчоо” нэртэйгээр сонгодог монгол бичгийн хэлээр гар бичмэлээр хэвлэсэн байна. Түүнийг долоон бүлэгтэй хэвлэжээ.



Оршил үгэнд бичихдээ: “Хуучин тогтоолын ариун шаштирын товчоо дэвтэрийн дотор тэнгэрийн эзэн тэнгэр дэлхийг бүтээснээс эхлэн аврагч мандсан дор хүртлэх хэрэг явдлыг тайлбарламой.

Хуучин тогтоолын ариун шаштирын товчоо хэмээгч энэ нэгэн дэвтрийг долоон их улирлын хугацаа болгон хуваамуй.

Нэгдүгээр хугацааны дотор анхан язгуурын хэрэг явдлыг шүүмжилмүй.

Хоёрдугаар хугацааны дотор Абрахаам, Исаак, Яков хэмээгч гурван овог ичсэн цагийн явдлыг шүүмжилмүй.

Гуравдугаар хугацаанд Моссийн цагийн явдлыг шүүмжилмүй.




Дөрөвдүгээр хугацаа дотор Иосеф ба Израиль улсыг шүүгч түшмэдийн цагийн хэрэг явдлыг шүүмжилмүй.

Тавдугаар хугацааны дотор улсын вангуудыг шүүмжилмүй.

Зургадугаар хугацааны дотор Вавилонд цөлөгдсөн цагийн явдлыг шүүмжилмүй.


Долдугаар хугацааны дотор цөлөгдсөн газраас нутагтаа харьж ирсний сөнөнги цагийн явдлыг шүүмжилмүй . . . ” хэмээн өгүүлснээс эл бүтээлийн хэл найруулгын онцлог, Хуучин гэрээний агуулгыг хэрхэн илэрхийлсэн байдал, тогтсон нэр томьёог монгол бичгийн хэлээр хэрхэн тэмдэглэснийг бэлхэнээ харж болж байна. Энд God-ийг “Тэнгэр эзэн ” гэж орчуулжээ.

Орчуулгын эхлэл үгэнд орчуулагчийн олсон хувь нь дутуу бөгөөд дутсан хэдэн цаасыг өөр эхээс нөхөн хуулж бичсэнээ ч өгүүлсэн нь бий.



1952 онд Хон Конгийн Библийн нийгэмлэгээс Шинэ Гэрээний орчуулгыг Стюарт Гунзел \Stuart Gunzel\ монголчуудтай хамтран засварласныг 8000 хувь хэвлэсэн байна. Энэ ажилд Гэндэн, Рэнчиндорж хэмээх монгол хүмүүс оролцсон бөгөөд Стюарт Гунзел тус багийнхныг Хонконгод удирдан ажлаа дуусгажээ. Үүнийг японы иргэн Китакура 1998, 2005 онд тус тус хянан тохтолдуулж дахин хэвлэсэн юм. 2005 оны хэвлэл нь . . . оноосон нэрийг Библийн монгол хэл дээрх бусад орчуулгын хэлбэрт орчуулах, орчуулгыг сайжруулах, алдаануудыг засах, өмнөх орчуулгуудаас оновчтой орчуулахыг чармайсанаараа онцлог болсон хэмээжээ. Тус хэвлэл багавтар үгийн тайлбартай ба үгийг хатуу бариагүй утгачилсан орчуулга болсон байна.

Анхны монгол хэлт Шинэ гэрээ хэвлэгдэхэд буриадууд Санкт Петербург хотод очиж ажиллаж байсан бол энэ удаа монголчууд Хон Конгод ажиллажээ.



Шинэ гэрээг "Шинэ Тестмент" нэртэйгээр хэд хэдэн удаа хэвлэсэн байдаг. Testament буюу Гэрээ, Гэрээс гэх үгийг орчуулалгүйгээр уг эхээр нь зээлдэн авч "Бидний эзэн ба аврагч Исүс Христийн Шинэ Тестмент хэмээгч шинэ болзооны ном" хэмээсэн нэрээр монгол бичгээр хэвлэсэн энэ орчуулга нь өмнөх хувилбаруудыг бодвол элбэг байдаг.

"Ариун номын үлгэр" \зураг баруун гар талд\ нэртэйгээр Өвөр Монголын соёлын хэвлэлийн хорооноос 1981 онд хэвлэжээ. Найруулагчийн үг хэмээх өмнөтгөлд . . . Манай Дундад Улсын хүмүүн европ тив, америк тивийн соёл, түүх, гүн ухаан, аж ахуй, хууль цаазыг судлыа гэвэл "Ариун ном"-той танилцахгүй байж чадахгүй" хэмээн Библийн судрыг европ дахины соёл, түүх, гүн ухаан, аж ахуй, хууль цаазыг судлах эх сурвалж хэмээн үзсэн байдаг.

Библийн судрын Хуучин гэрээний "Гарсан нь" бүлэг бүхэлдээ хууль эрх зүйн шинж чанартай байдаг. Энд тухайн үеийн тухайн газар нутгийн иргэдийн амьдарал үйл ажиллагаандаа баримтлах дэг журмыг нарийн гаргасан нь бий юм. Харин "эхлэл" бүлэг Христос болон Иудайн шашины ертөнцийн гарал үүслийн талаарх үзэл сургаал байдгийг бид мэдэх юм.

XIX зууны эхэн үед монгол хэлнээ Библийн доторх номууд дангаараа хэвлэгдэж ирэв.

Үүнд:




Эдгээр орчуулгуудын онцлог нь монгол хэлний ярианы хэлэнд илүү ойр орчуулагдсан шиг байдаг.

"Эстээр бүсгүйн түүх" хэмээх товхимолд Библи судрын Рүүт бүсгүйн түүх, Гүн ухаантны сургаал, Ертөнцийн Эзэний зарлага Ионах гэх 3 номыг нэг дор оруулсан байна.

Гүн ухаантны сургаал хэмээх номоор Христосын шашны хүний амьдралын утга учрын талаарх үзэл сургаалыг мэдэх нэгэн эх сурвалж болдог гэж үзэж болно. Эл ном "Орчлонд бүх юм утгагүй. Утгатай юм огт байхгүй гэдгийг гүн ухаантан би хэлж чадна" хэмээн эхлээд "... өслөөний наран зүүнээс мандаж, орой нь баруунаа шингэвч ахиад л бахь байдгаараа маргааш нь зүүнээс мандана. ... Мөрөн голын бүх ус хөлгүй далайд цутгавч дүүргэж чадсан удаагүй. Харин ч эргээд эх авсан газар уруугаа урсаад одно. Ийнхүү аваад үзвэл юм бүхэн хэлэхийн аргагүй залхуутай. Тэвчихийн аргагүй уйтгартай. ... Ингээд би гүн мэргэн ухаан болон хүний тэнэг санаа гэгч юу болохыг ойлгох гэж оролдсон боловч энэ нь салхи барихаар хөөцөлдөх мэт үр ашиггүй болохыг мэдэв. ... Амьдралын их мэдлэгтэй болох нь өөртөө зовлон нэмнэ гэсэн үг юм" хэмээсэн байдаг.

1980-аад оны сүүл, 90-ээд оны эхээр ардчилсан нийгэмд шилжсэн монголчууд гадаадын иргэдтэй гэр бүл болох явдал илт нэмэгдсэн юм. Жон Гиббенс (John Gibbens) гэх эртэй монгол Алтанчимэг гэх эмэгтэй гэр бүл болж Шинэ Гэрээг монгол хэлээр орчуулж 1990 оны намар Хон Конг дахь "Библийн Нэгдсэн Нийгэмлэг"-ээс хэвлэн нийтэлжээ.

Ингээж монгол хэл дээрх Библиүүд ямагт гадаадад хэвлэгдсээр иржээ.



Энэ орчуулга өмнөх орчуулгуудаас нэлээд ялгаатай. Юуны өмнө оршил хэсэгтэй бөгөөд эл оршилд Есүс Христ гэж хэн бэ, яагаад түүнд итгэх хэрэгтэй вэ, тэр хэнд тусалдаг вэ гэхчлэн Христосын шашны итгэл үнэмшлийн асуудлыг тайлбарлан бичсэн байдаг. Тэд ертөнцийн эзнийг үгүйсгэдэг үзэлтнүүдийг "“Зөвхөн тэнэг мунхаг хүмүүс Ертөнцийн эзэн байхгүй гэж боддог”, (“Дуулал” 14 дүгээр дуу, 1-р зүйл)” хэмээн эшлэн бичжээ.¹¹ Орчуулагчид номынхоо ач холбогдлыг “Даян дэлхийд олон хүн Есүсийг өөрийн аврагч гэж итгэн, шинэ амьдралыг олж авдаг юм. Та ч энэ номыг уншаад Есүс Христэд ойртохыг хүс. Энэ бол чийдэнгийн унтраалга дарах мэт хялбар асуудал бөгөөд таны амьдралд гэнэт гэрэл тусан туяарч, урьд ухаараагүй явсан олон юмыг та ойлгож эхлэх болно”¹² хэмээсэн бий.

Мөн түүнчлэн Гиббенсийн гэр бүлийн тус орчуулгын бас нэгэн онцлог нь Хуучин гэрээнээс эш татаж жишээлсэн, зүүлттэй, ардаа үгийн тайлбартай юм. Энэ орчуулгыг нэр томьёоны хувьд Буддизмийн нэр томьёог ашиглаагүй гэж үздэг.

Монголын Библийн Орчуулгын Хороо (одоогийн Монголын Библийн Нэгдсэн Нийгэмлэг) 1991 оноос Библийг орчуулж 1995 онд Марк, Иохан, 1996 онд Шинэ Гэрээг хэвлэн гаргажээ. Тус шинэ орчуулгын онцлог нь уламжлалт “Бурхан” гэдэг нэр томьёог дахин хэрэглэж, үгчилсэн байдлаар орчуулах зарчмыг баримлан англи хэл дээрх New American Standard гэх орчуулгыг эх текстээ болгосон байна. Тэрчлэн 2000 онд Хуучин ба Шинэ гэрээ хамтдаа хэвлэгдсэн нь кирил үсгээрх анхны бүтэн Библи болов. Энэ хувилбар хамгийн өргөн хэрэглэгдэж байгаа Библи болно.

Гиббенсийн гэр бүл болон Монголын Библийн Орчуулгын хорооны хооронд Библийн орчуулгын хувьд зарчмын ялгаатай байр суурь баримталдаг. Гиббенсийнхэн “Бурхан” гэж

11. Шинэ Гэрээ. Олон Улсын Библийн нэгдсэн нийгэмлэг. Хонконг., 1990, 3 дахь тал.

12. Мөн тэнд, 9 дэх тал


орчуулсан категори "Ертөнцийн эзэн" буюу "Lord of the World" гэх категориор тэмдэглэх ёстой гэж үздэг. Тийм ч учраас тэдний орчуулгууд нэр томъёоны хувьд ялгаатай байдаг. Ялангуяа God гэдэг нэр томъёог Бурхан гэдэг категориор тэмдэглэсэнийг эсэргүүцдэг.

"Ариун Библи Нийгэмлэг" 2004, 2008 онуудад өмнөх орчуулгуудыг редакторлон хэвлүүлсэн юм. Орчуулгуудын талаар янз бүрийн санал байдаг. Ихэнхдээ, үгчилсэн орчуулга учир олон зүйлийг ойлгоход бэрх гэж шүүмжилдэг.



Монгол хэл дээр хэвлэгдсэн нэлээд олон Библи Японд хэвлэгдсэн байдаг. Бичгийн машинаар цохиж дараа нь олируулсан энэ хувилбар хэд хэдэн дэвтэрээр хэвлэгдсэн бололтой, гэвч бид бусад дэвтрийг олж үзсэнгүй. Эл дэвтэр 1993 онд хэвлэгджээ. Тус дэвтэрт Маффейсийн бичсэн тэмдэглэл, Маркосын бичсэн тэмдэглэл, Лукасын бичсэн тэмдэглэл гэсэн Шинэ Гэрээний эхний гурван номыг нэгтгэн оруулжээ¹³. Эдгээр номын нэрсийг зарим Шинэ Гэрээнд Матай, Маарх, Луух гэж нэрлэсэн байдаг¹⁴. Ингэж Библийн судрын орчуулгын хэл найруулга өөрчлөгдөж байгаа нь түүнийг олон янзаар орчуулж байгаагийн нотолгоо болохын зэрэгцээ дундаж хувилбарыг гаргах гэсэн оролдлого мөн байх.

Нээлттэй нийгэмд шилжсэн, зах зээлийн эдийн засгийн эхэн үед монголчуудад өрнөдийн хэлийг сурах нь чухал байв. Ингэх нь 3 дахь зах зээлд нэвтрэх, гадаадын хөрөнгө оруулагчидтай шууд харилцах өргөн боломж байв. Энэ хэрэгцээ шаардлагыг Христосын шашины зүтгэлтнүүд соргоогоор мэдэрч Библийг англи-монгол хэл дээр хэвлэж байв. Англи хэл сурах хүсэлтэй залуус англи-монгол хэл дээр хэвлэгдсэн Библийг унших нь нэлээд түгээмэл байсан юм. Зураг баруун гар талд Энд байгаа Шинэ Гэрээ нь 1993 оны 10 сард "Монгол Баярын Мэдээ" хэмээх ББХК-ий хэвлэсэн хэвлэл болно. Библийн англи, монгол хувилбарыг нэг хуудсан дээр зэрэгцүүлэн хэвлэсэн нь гадаад хэл сонирхон судлагчдад тустай гарын авлага болсон байгаа юм.



1996 онд "Монгол Библийн Орчуулгын Хороо"-ноос Шинэ Гэрээг хэвлэн гаргав.

Орчуулгын өмнөх үгэнд энэ орчуулгын бүтээлийг монгол итгэгчид өөрсдийн санаачлагаар


13. Шинэ Гэрээ. I боть, Fukui Shuppan-sha, Japan., 1993

14. Шинэ Гэрээ, Олон Улсын Библийн Нэгдсэн Нийгэмлэг, Хон Конг. 1990

монгол хэлнээ хөрвүүлсэн гэжээ.¹⁵ Мөн орчуулгыг грек эхтэй нь тулган нягталсан байна. Орчуулагчид хэдийгээр библийн үгчилсэн орчуулга чухал ч гэтлээ утга санааг нь бүрэн гаргах нь түүнээс чухал гэх байр суурийг баримталж орчуулгыг хийсэн байна. Гэсэн хэдий ч энд Бурханы Үг монголчуудад хамгийн зөвөөр хүрэхийн тулд зарим зүйл дээр үгчилсэн орчуулга хийснээ тайлбарлажээ. Нэг үгээр бол уг эхийг гажуудуулах, библийн үндсэн санааг гаргахад найруулга зүйн зарчмаас зарим талаар хазайхаас өөр аргагүй байдаг гэсэн санаа харагддаг юм. Тус орчуулгад нэр томъёоны гайгүй сайн тайлбарыг хавсаргасан нь бий.

1996 онд Монголын Библийн Нийгэмлэгээс Шинэ Гэрээг латин болон иврит¹⁶ хэлнээс нь дахин орчуулж хэвлэжээ. Харамсалтай энэ номоос "шилэл авах"-ийг дотор нүүрэндээ тусгайлан хориглосон нь нэн сонин болно.

Монголын Библийн Орчуулгын Холбооноос 1998 онд Улаанбаатар хотноо Шинэ Гэрээг дахин хэвлэв. Энэ орчуулга 1993 онд японд хэвлэгдсэн Шинэ Гэрээтэй ойлголтуудыг оноосон байдлаараа нэлээд төстэй байдаг. Шинэ Гэрээний бүлгүүдийн нэрс үндсэндээ тохирдог. 1993 оны хэвлэлээс ялгаатай нь Шинэ Гэрээ бүтэн 27 бүлгээрээ орчуулагдаж орсон байдаг. Орчуулагчид энэ бүтээлээ итгэгч, итгэгч биш бүх хүнд зориулсан гэжээ. Үл итгэгчид нь итгэгчдээс хавьгүй олон учир үл итгэгчдийг илүү харгалзаж энэ орчуулгыг хийсэн тул утгачлан орчуулах арга зүйг гол удирдамжаа болгож орчуулгыг үйлдсэн байна (зураг хамгийн баруун талд).



Библийн судалгааны ном, гарын авлага хангалттай биш учир 1996 онд хэвлэгдсэн Томас Хэйл (Tomas Hale), Стефан Торсон (Stephen Thorson) нарын "Шинэ Гэрээний Хэрэглээний тайлбар толь"-ийг 2004 онд "Монголын Теологийн Өргөтгөсөн Сургууль"-иас орчуулан гаргасан байна. Эл толинд крилл үсгийн цагаан толгойн үсэг дарааллаар Христосын шашины нэр томъёо, категориудыг тайлбарласан бөгөөд Шинэ Гэрээний номуудын агуулгад нийцсэн нийтлэлүүдийг хавсаргасан болно.

2008 онд 1840 оны Хуучин Гэрээний монгол орчуулга, 1950 оны Свансоны Шинэ Гэрээний орчуулгыг нийлүүлэн Япон улсад Библийг монгол хэл дээр "Ариун Ном" (зураг баруун гар талд) нэртэйгээр бүрнээр нь хэвлэв. Эл хэвлэлээр бид монгол хэл дээрх анхны Хуучин гэрээний орчуулгатай танилцаж байна.

Тус хэвлэл томоохон эрдэм шинжилгээний удиртгал үгтэй. Удиртгалд 1840 оны Хуучин Гэрээний орчуулгад Буддын нэр томъёог өргөн хэрэглэсэн нь гол сул тал гэж дүгнэсэн

15. Библи. Шинэ Гэрээ. Монгол Библи Орчуулгын Хороо. 1996

16. Еврей хэлийг Иврит хэл гэдэг.

байна. Ингэхдээ "... буддын шашны үг хэллээс нөхөн монголчуудын өдөр тутмын амьдралд хэрэглэдэг үхтэй аяндаа хөтлөдөг хэрэглэгдсэн нь хэд хэдэн тохиолдоор харагддаг" хэмээн найрагч агуутайхан нүүмжлээд тухайн үед англи хэл мэддэг хүн цөөн учир ариун номын нэр томъёог дутуу орхисон, буруу орчуулсан зүйлс бий тухай бичжээ¹⁷. Элохим (God) –ийг Бурхан, Buddha хаан, тахич (priest)-ийг лам хэмээн орчуулсан нь буруу хэмээсэн байна.

Ялангуяа "Бурхан" хэмээх ойлголт төвд хэлнээс монгол хэлэнд орсон гэж үзсэн нь бидний судалгаанаас нэлээд зөрөөтэй байгаа юм. Бурхан гэдэг нэр томъёог Деревниетюркский словарьт тайлбарлахдаа 1.будда- нирваанд хүрсэн бие хүн 2.Будда буюу Буддын сургаалийг үндэслэгч хэмээн тайлбарласан байдаг бөгөөд эл үг уйгар хэлнээс монгол хэлэнд орсон нь тогтоогдсон юм.

Орчуулгын удиртгал дахь нтгэгчдийн Элохим хэмээх ойлголтын талаар тайлбарласан нь ихээхэн сонирхолтой бөгөөд түүний олон хувилбаруудын талаар ялгаж бичсэн байна. Бас монголчуудын "Тэнгэр" хэмээх ойлголтыг Эзэн тэнгэр гэдэг ойлголттой холбож тайлбарлажээ.

Дээрхүүдээс үзэхэд Библийн монгол хэл дээрх анхны хувилбаруудаас Edward Stallybrass, William Swan нарын орчуулга бүрэн, хэл найруулга сайтай учир бусад орчуулгуудын гол эх сурвалж болж байсан нь тодорхой байна. Өнөө хэр монгол дахь Библи судрыг орчуулдаг албан ёсны байгууллагууд ч эл хувилбарыг барьдаг юм байна.

Энд оцлон хэлэхэд сүүлийн үеийн Библи судрын орчуулгууд арвин буй бөгөөд хаана хэвлэсэн, хэдэн хувь хэвлэсэн, ямар хэлний аль эх сурвалжийг барьж орчуулсан зэргээ хэвлэл дээрээ заагаагүй байх нь бий. Бас агуулга, өмнөх үг, удиртгал, оршил, төгсгөлийн үтгүй байх нь элбэг.

Дээр хэлсэнчлэн Христосын шашинт олон улс үндэстнүүд өөрсдийн шүтдэг шашны судар номыг төрөлх хэл дээрээ унших, зан үйлийг нь өөрийн хэлээрээ хөтлөн явуулах хэрэгцээ шаардлагаар Библийн судрыг орчуулсан байдаг бол монгол хэлнээ эл судар хөрвүүлэгдсэн нь монголд тухайн шашны номлол сургаалыг дэлгэрүүлэх сонирхол бүхий Христийн шашны байгуулга, зүтгэлтэн, гадаадын хүмүүсийн үйл ажиллагаа байсан байна. Эл ажилд нэлээдгүй мөнгө санхүү зарлагдсан нь ч тодорхой бөгөөд хэвлэгдсэн байдал, хэвлэсэн тоо нь үүнийг батлан харуулдаг юм. Ингэх нь христос шашинтны шашныхаа өмнө хүлээсэн "ариун" үүргээ биелүүлж байсан хэрэг биз ээ. Зарим талаар монголчуудын хэсэг нь Христосын шашны үзэл сургаалд орж түүний эх сурвалжийн агуулгыг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэх хүсэл сонирхол байсныг хэлэх нь зүйтэй юм.

НОМ ЗҮЙ

1. Шинэ гэрээ. 1840.
2. William Smith, Smith's Bible dictionary (Dictionary of the Bible). 1863
3. Хуучин тогтоолын ариун шаштир. 1935
4. Шинэ Тестмент. 1952
5. Ариун номын үлгэр. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1981
6. Шинэ Гэрээ. Олон Улсын Библийн нэгдсэн нийгэмлэг. Хонконг., 1990, 3 дахь тал.
7. Шинэ Гэрээ, Олон Улсын Библийн Нэгдсэн Нийгэмлэг. Хон Конг. 1990
8. Иовын түүх. Олон Улсын Библийн Нэгдсэн Нийгэмлэг. 1990
9. Шинэ Гэрээ. I боть, Fukuin Shuppan-aha, Japan., 1993
10. Шинэ Гэрээс, Монгол-Англи Библи. УБ., 1993
11. Библи. Шинэ Гэрээ, Монгол Библи Орчуулгын Хороо. 1996
12. Лори Ёнкор. Колосай номыг судлах нь. Христчин чөлөөт сүм. УБ., 1999

17. Ариун ном. Япон. 2008.

13. Шинэ Гэрээ, Монголын Библийн Нийгэмлэг. УБ., 2001
14. Ариун Библи. Ариун бичээс Библийн Нийгэмлэг. УБ., 2004
15. Шинэ Гэрээний Хэрэглээний Тайлбар толь. Томас Хэйл. МТӨС.УБ., 2004
16. Библийн зурагт тайлбар толь. Давид Александр. УБ., 2004
17. Библийн Хураангуй толь бичиг Ж.Д.Дуглас, Меррилл С. Тенни. УБ., 2004
18. Бялхам Амь Судлал Библи. Ариун бичээс Библийн Нийгэмлэг. УБ., 2006.
19. Ариун ном. Япон. 2008.
20. The Illustrated encyclopedia of World Religions, general editor Chris Richards. Great Britain, 1997
21. The World book Encyclopedia, USA, 1997
22. Meriam-Websters'. Encyclopedia of World Religions \Wendy Doniger, consulting editor\ USA, 1999
23. Народы и религии Мира, Энциклопедия, Научное издательство "Большая Российская Энциклопедия" М., 1999
24. John Bowker. World Religions: Great faiths explored & explained. New York., 2003
25. Robert Alter. Five books of Moses. London, 2004
26. Scriptures of the World's Religions. Second edition, edited by James Fieser, John Powers. New York. 2004
27. Britannica.Micropaedia, Ready reference. USA, 2005
28. Оюуны хэлхээ II, Christianity and Mongolia, Ulaanbaatar., 2006
29. У.Эрдэнэбат. Дундад зууны монгол оронд загалмайтны шашны урсгал нэвтэрч байсан товч түүхээс. УБ., 2009, Monograjh series, Volume 2, Антоон Мостаэрт Монгол Судлалын Төв.
30. Britannica ширээний нэвтэрхий толь, УБ., 2011
31. Olga Volkova. The First Western Missionaries in Buratia. Swedish Missiological Themes. Svensk Missions Tidskrift. Vol.93, No.1,
32. <http://www.greatsite.com/timeline-english-bible-history/>

ABSTRACT

In this article we wrote about history of Bible translation into Mongolian. Mongolians translated religios sources such as Buddhas teaching from middle age.

About Bible in Mongolian language belongs to beginning of XIX century. Isaac Smidt translated Old Testament into Mongolian first. New Testament translated in 1840-1846 by Eduard Stallybrass, William Swan. Translators lived in Siberia for long time and studied Mongolian language. In this version buriats such as Nomt, Badma, Renchin joined by teir request.

Russian Emperor and British&Foreign Bible society gave a big influense to translate Bible into Mongolian language, but Mongolians themselves.